



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2022 оны 05 сарын 12 өдөр

Дугаар 1/272

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны "Төрийн өмчийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг байгуулах тухай" 138 дугаар тогтоол, Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 5 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.

2. Засгийн газрын 2022 оны 138 дугаар тогтоолоор Медипас эмнэлгийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын "Эрдэнэт медикал" төрийн өмчит төрөлжсөн эмнэлэг болгон өөрчлөн байгуулснаар орон нутгийн иргэдэд тусламж, үйлчилгээг цаг алдалгүй, тасралтгүй хүргэх нөхцөл байдал, эмнэлгийн үйл ажиллагааг хэвийн явуулж байгааг харгалзан үзэж Магадлан итгэмжлэлийг 2023 оны 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэл олгосугай.

3. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /П.Эрхэмбаяр/, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/ -д тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай

САЙД



С.ЭНХБОЛД

141221313

Эрүүл мэндийн сайдын 2022 оны  
дугаар сарын 12 ны өдрийн  
дугаар тушаалын хавсралт

05  
1/272

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн Дугаар	Магадлан итгэмжлэг- дсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв	124/2022	2 жил	2022.04.21	2024.04.21

---o0o0o---